

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР ¹ 27 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 14.30 цагт эхэлж, 16.30 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 2 цаг 00 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газрын дарга нарын ажлын байрны тодорхойлолтын тухай	<p>1.ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газрын Төрийн захиргааны удирдлагын газрын даргын ажлын байрны чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн учир одоо ажиллаж байгаа хүн нь үргэлжлэн ажиллана гэж үзэж, уг ажлын байранд сонгон шалгаруулалт зарлахгүй,</p> <p>2.ЗГ-ын агентлаг Оюуны өмчийн газрын Аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрхийн хэлтсийн даргын ажлын байранд орон тоо хасагдсан гэж үзэж, одоо ажиллаж байгаа 2 хүнээсээ аль тохирохыг нь сонгон шалгаруулж, ТАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.2.3-т заасны дагуу шийдвэрлэ гэсэн зарчим барих,</p> <p>3.ЗГ-ын агентлаг Оюуны өмчийн газрын Төлөвлөлт, бодлого, хамтын ажиллагааны хэлтсийн даргын ажлын байр нь бүтэц шинээр батлагдахад шинээр бий болсон байх тул энэ ажлын байранд нэг бол дотроосоо хүнээ сонгож тавих, эсвэл удирдах ажилтны нөөцөөсөө сонгож томилж болно, хэрвээ тийм боломжгүй бол ийм боломжгүй гэсэн тайлбартайгаа тус Зөвлөлд захиалга өгч, шинээр сонгон шалгаруулалт зарлах нь зүйтэй гэж ЗГ-ын агентлаг Оюуны өмчийн газарт хариу явуулахаар болов.</p>
2	Засгийн газрын тохируулагч агентлаг Онцгой байдлын ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	МУ-ын ЗГ-ын тохируулагч агентлаг Онцгой байдлын ерөнхий газрын дэд даргын албан тушаалд Түвшингийн Бадралыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Монгол Улсын шадар сайд М.Энхболдод санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
3	Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байсан Баадайн Пүрэвдоржийн төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх хүсэлтийн тухай	1990-1992 онд БНМАУ-ын Бага Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байсан Баадайн Пүрэвдоржийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
4	Засгийн газрын тохируулагч агентлаг	МУ-ын ЗГ-ын тохируулагч агентлаг Мэдээлэл,

	Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газрын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	шуудан, харилцаа холбоо, технологийн газрын Статистик мэдээлэл, хяналт-шинжилгээний хэлтсийн даргын албан тушаалд Өлзийхутагийн Одгэрэлийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж МУ-ын ЗГ-ын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансарт санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
5	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дэд даргын албан тушаалд Зэнээмядарын Батбаярыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
6	Засгийн газрын тохируулагч агентлаг Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэдэх ТАЗСЗ-ийн бүрэлдэхүүнийг: Даргаар –Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, гишүүдэд –Зэвсэгт хүчний жанжин штабын дэд дарга, Ерөнхий зориулалтын цэргийн командлагч, Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлагч, J-3 Ажиллагааны удирдлагын газрын дарга, J-4 Цэргийн хангалт үйлчилгээний газрын дарга, J-5 Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга, Зэвсэгт хүчний ерөнхий хянан шалгагч, газрын дарга, J-1 Хүний нөөцийн хэлтсийн дарга, Зэвсэгт хүчний жанжин штабын ахлагч, Хүний нөөцийн хэлтсийн хүний нөөцийн нөхөн хангалтын албаны дарга, хүний нөөцийн ахлах мэргэжилтэн (Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга) гэсэн 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
7	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Татварын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Татварын ерөнхий газрын дэргэдэх ТАЗСЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай асуудлыг хойшлуулах нь зүйтэй гэж үзэв.
8	Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт зохион байгуулсан дүнгийн тухай	<p>1.2009 оны 12 дугаар сарын 19, 20-ны өдөр зохион байгуулсан Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1648 иргэн (20 аймгийн 1648)-ийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэснийг 1-20 дугаар хавсралтаар батлах,</p> <p>2.Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нь санал болгож, томилуулахыг Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга болон аймаг дахь ТАЗСЗ-ийн дарга нарт үүрэг болгох,</p> <p>3.Нутгийн захиргааны байгууллагын салбар комиссоос 2009 оны 12 дугаар сарын 19, 20-ны өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн Ховд аймгийн</p>

		<p>Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албаны 1, Улсын бүртгэлийн хорооны 1, Баян-Өлгий аймгийн Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албаны 1, Улсын бүртгэлийн хорооны 1, Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хорооны 1, Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хорооны 1, Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хорооны 1, Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хорооны 2, Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хорооны 1 ажилтныг хавсралтаар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн бүртгэлд бүртгэх,</p> <p>4.Энэ тогтоолын хавсралтад дурдсан иргэдийг тухайн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэн томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус хүргүүлэх тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.</p>
9	Бусад асуудал: ЗГ-ын тохируулагч агентлаг Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд даргын албан тушаалд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах тухай	ЗГ-ын тохируулагч агентлаг Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд даргын албан тушаалд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нь зүйтэй гэж үзэв.
10	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан технологийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан технологийн газрын даргын албан тушаалд Өлзийбатын Сүхбаатарыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжавт санал болгох тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.